



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 1573

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин өрхийн эмнэлгийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Т.Гантулга -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон
нутгийн өмчийн газрын ажил худалдан авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Мөнхцэцэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн


Т.Нарангарав -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
төлөөлөгч

Б.Одсүрэн -Мерси кор ОУБ-ын Өвөрхангай аймаг дахь
салбарын зохицуулагч (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101046